

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№3 (11)

2021.06.21

МЯНГАНЫ СОРИЛТЫН ХОЁР ДАХЬ КОМПАКТ ГЭРЭЭНИЙ НИЙГМИЙН ХҮРТЭЭМЖИТ БАЙДАЛ: УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ НЬ



Эрчим хүч, ус хангамж зэрэг төрийн үйлчилгээг бага орлоготой, хөдөө орон нутгийн, амьдралын боломж муутай өрхүүдэд илүү хямд, хүртээмжтэйгээр хүргэх нь Мянганы Сорилтын корпорацын дэд бүтцийн хөрөнгө оруулалтад нийгмийн оролцоог хангах нэг томоохон хүчин зүйл юм. Үүний тулд оролцогч талуудтай зөвлөлдөж, хүн ам зүй, өрхийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар, баримт судалгаанд суурилсан бодлогын шийдвэрийг дэмжих шаардлагатай. Монгол Улсад хэрэгжүүлж буй Усны Компакт гэрээ нь нийгмийн хүртээмжит байдал, баримт судалгаанд суурилсан бодлого

боловсруулалтыг эн тэргүүнд тавьсан хөрөнгө оруулалтын нэг тод жишээ юм. Компакт гэрээний хүрээнд нийслэл Улаанбаатар хотын хурдацтай өсөн нэмэгдэж буй хүн амын унд, ахуй, үйлдвэрлэл үйлчилгээний усны эрэлтийг хангах, болзошгүй усны хомстлоос урьдчилан сэргийлэх зорилгоор усны салбарын дэд бүтцийг өргөтгөж сайжруулах бөгөөд улмаар сайжруулсан дэд бүтцийн хэвийн, үр ашигтай үйл ажиллагааг хангах үүднээс үнэ тарифт тодорхой хэмжээний өөрчлөлт гарсан тохиолдолд ч хэрэглэгчдийн худалдан авах чадварт нийцсэн үнээр ус хангамжийн үйлчилгээг хүргэхэд энэ Компактын нийгмийн хүртээмжит байдлыг хангах гол зорилго оршиж байгаа юм...

[Эх сурвалж: Монголын Мянганы сорилтын сан, Мянганы сорилтын корпорац](#)

19 АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУУЛ ГОЛЫН ЭРЭГ ДАГУУ ГАЗАР АШИГЛАХ, ЭЗЭМШИХ ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЛОО

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар Хан-Уул дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу “Хан хиллс” хотхоноос баруун тийш Туул голын эрэг дагуу газар авч, барилга барих нэрээр Туул голын бургасанд аюул учруулж байгаатай холбоотойгоор өнгөрсөн тавдугаар сард газар дээр нь очиж ажилласан. Туул голын хойд эрэг дагуу 2008 оноос хойш 22 аж ахуйн нэгжид газар олгосон байдаг. Үүнээс 19 газар эзэмшигч нь барилгын ажлаа эхлүүлээгүй, зарим компани шөнийн цагаар их хэмжээний хайрга, дайргыг бургаснууд дээр асгаж, гэмтээж байсан юм. Иймээс Нийслэлийн Засаг даргын захирамжаар Туул голын эрэг дагуу амины болон орон сууц зэрэг зориулалтаар газар эзэмшиж байсан 19 аж ахуйн нэгжийн газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болголоо. Цаашид усан сан болон ойн сангийн бүсэд газар эзэмшиж буй иргэн хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг үе шаттайгаар цуцална.

[Эх сурвалж: Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба](#)

"БОРООНЫ УСААР УЛААНБААТАРЫН ГУРВАН ЖИЛИЙН УСНЫ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ БОЛОМЖТОЙ"



Манай орны нутаг дэвсгэрт орж буй борооны ус жалга, гуугаар дамжин голын усанд нийлдэг ба тэдгээр бүх гол гадагшаа урсдаг. Энэ нь бид маш их хэмжээний хэрэглэж болохуйц усаа гадагш алдаж байна гэсэн үг. Улаанбаатар хотод дунджаар жилд 250 мм (1 м2 талбайд жилд 250 литр ус) хур тунадас унадаг. Харин ургамал бүрэн ургахын тулд жилд 1000 мм хур тунадас буюу чийг шаардлагатай байдаг. Тиймдээ ч манай орон харьцангуй хуурай бүс нутагтай улсуудын тоонд ордог. Гэхдээ хур тунадсыг хуримтлуулж хэрэглэвэл ахуйн хэрэглээгээ хангаж боломжтой юм. Монконсалт ХХК-

ийн төслийн менежер Б.Дашнямын ярьснаар “Хэрэв “Туул голын усан цогцолбор” буюу далан баривал Улаанбаатар хотын 2-3 жилийн усны хэрэгцээг зөвхөн хуримтлуулсан борооны усаар хангах боломжтой” аж.


[Эх сурвалж: gogo.mn](#)

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ БАЙГАЛЬ ХАМГААЛАХАД ЗАРЦУУЛДАГГҮЙ БАЙДАЛ НИЙТЛЭГ БАЙНА

Төсвийн жилд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь нэгдсэн дүнгээр 2012 онд 40 тэрбум байсан бол 2019 онд 94 тэрбум, 2020 онд 112 тэрбум төгрөгт хүрч жилээс жилд өссөн байна. Гэвч үүнээс 40 хүрэхгүй хувийг нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулжээ. Зарим тохиолдолд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөгөөнөөс давж биелдэг ч эдгээр орлогыг байгаль хамгаалахад зарцуулдаггүй байдал орон нутагт нийтлэг байгаа аж. Тухайлбал 2019 онд орон нутгийн төсөвт орох байгаль нөөц ашигласны төлбөрийн орлогыг 76 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч төсвийн гүйцэтгэлээр 26.5 тэрбум төгрөгийн орлого давж биелсэн ч энэ хөрөнгө мөн зориулалт бусаар зарцуулагдсан байдаг.

[Эх сурвалж: iToim.mn](#)

ТОВЧХОН



Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирал Э.Содонтогос "Миний Өглөө" подкастын 100 дахь дугаарын зочноор зочноор уригдан оролцож, “Ундны ус амьдралын булаг” сэдвээр сонирхолтой яриа өрнүүлэв. Ярилцлагыг Монголын Үндэсний Радиоогийн 1, 2, 3 дугаар сувгаар Даваа гарагт 7.30, 13.20, 22.00 цаг, Мягмар гарагт 9.30, 22.00 цаг, Лхагва гарагт 8.20 цаг, Баасан гарагт 7.30, 21.30 цаг, Бямба, Ням гаригт 7.30, 9.30, 20.00 цагаас тус тус шууд хүлээн авч сонсох боломжтой. Түүнчлэн anchor платформ дээр <https://tinyurl.com/46tsz88t>, apple платформ дээр <https://tinyurl.com/btkvf66w> холбоосоор сонсох боломжтой. [Эх сурвалж: Миний өглөө подкаст](#)

УСУГ Дусалхүү подкастынхаа ээлжит дугаарыг “[Бохир ус зөөврийн үйлчилгээний талаар](#)” сэдвээр хүргэж байна. Подкастын зочноор УСУГ-ын ХҮА-ний Бохирдуулагч үйлдвэрийн хяналтын инженер Б.Жамбалцанжид оролцож дээрх сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ [Эх сурвалж: УСУГ](#)

Үерлэсэн голын усыг хуримтлуулж, ногоон байгууламжаа усалж, автомашин угаах ашиглах боломжтой талаар Монголын мэдээ агентлаг [сонирхолтой сурвалжилга](#) бэлтгэжээ. [Эх сурвалж: MNB Монголын Мэдээ](#)